

НОЁН ХУТАГТ ДАНЗАНРАВЖААГИЙН ЗОХИОСОН АГВА
ДАЦАНГИЙН ЖАЯГИЙН ЖИШЭЭГЭЭР XIX ЗУУНЫ ҮЕИЙН БУДДЫН
ШАШНЫ МОНГОЛЧЛОЛЫН ТУХАЙ ӨГҮҮЛЭХ НЬ

Х.Фүтаки¹

Тавдугаар Ноён хутагт Данзанравжаагийн зохиосон жүжиг “Саран хөхөөний намтар”, шүлэг “Үлэмжийн чанар”, сургаал “Цаасан шувуу” зэрэг олон бүтээл Монголын уран зохиолын гүүхэнд чухал байр суурь эзэлсээр иржээ.

Харин Данзанравжаагийн шашны үйл ажиллагаа, үзэл баримтлалын тухай хийсэн бодитой судалгаа төдий л хангалттай биш санагдана. Судлаачид түүний бариулсан сүм хийдийн талаар цухас дурддаг боловч, тухайн сүм хийдэд хэрхэн хурал ном уншиж байсан талаар дэлгэрэнгүй гайлбарлаагүй байдаг. Данзанравжааг улааны чиглэлийн хутагт байсан гэж ихэнх эрдэмтэд үздэг боловч², буддын шашны яг аль урсгалыг баримтладаг байсан бэ гэдэг нь үнэндээ тодорхой биш гэж болно. Доктор Л.Хүрэлбаатар Данзанравжаагийн төвдөөр бичсэн зохиол “Аварга могойн зулайн чандмань” зэрэгт тулгуурлаж Тавдугаар Ноён хутагт “судрын ёс” ба “нууц тарнийн ёс”, “шарын ёс” ба “улааны ёс” эдгээрийг бүрэн салгаж болохгүй гэсэн байр суурьтай байсан гэж онцлон тэмдэглэсэн байна.³ Энэ нь дээр дурдсантай харьцуулбал илүү оновчтой мэт боловч, шарын болон улааны ёс хоёрын ялгааны талаар тийм нарийн дурдаагүй юм.

Ямар ч гэсэн Данзанравжаагийн шашны үйл ажиллагаа тодорхой бус байдаг гол шалтгаан нь бодитой баримт дутагдаж байгаад оршино гэж бодож байна. “Тахилчийн” дарж нууж амжсан Данзанравжаагийн хэдэн арван авдар ном, хэрэгслийн дотор зохих хэмжээний материал үлдсэн гэж үзэх үндэстэй боловч одоохондоо эдгээрийг бүрэн ашиглах боломж бүрэлдээгүй бололтой.

Би энэхүү өгүүлэлд Данзанравжаагийн зохиосон нэгэн жаягт тулгуурлаж түүний баруулсан дацанд ямар шашны үйл ажиллагаа явагдаж байсан тухай товч өгүүлэх болно.

Монголын буддын шашны бүх сүм хийд нь лам хуврагийн баримтлах ёстой жаяг⁴ дүрэмтэй байсан юм. Голдуу нэртэй хутагт хувилгаанаар төвд хэлээр жаяг зохиолгодог уламжлалтай байжээ.

1. Японы Токио Гадаад Судлалын Их Сургууль

2. Д.Цэрэнсодном, *Монголын бурханы шашны уран зохиол, тэргүүн дэвтэр*, Улаанбаатар, 1997, р. 144.

3. Л.Хүрэлбаатар, *Аварга могойн зулайн чандмань*, Улаанбаатар, 2006, pp. 235-236.

4. Төвд хэлээр *bea'yig*. 2012 оны 8 дугаар сарын 7-ны байдлаар TBRC (*Tibetan Buddhist Resource Center*)-д төвдөөр бичсэн 162 төрлийн жаяг бүртгэгдсэн бөгөөд 39 төрөл нь вэб хуудсанд нь тавигдсан. Эдгээрийн дотор Өвөр монголын сүм хийлд зориулсан жаяг цөөнгүй харагдаж байна.

Х.Фүтаки

Энд авч үзэх жаяг нь хувийн цуглуулгад байгаа бөгөөд *Тавдугаар Ноён Гэгээнтний зохиосон Агва дацангийн жаяг дэглэм гүнжэдийн зэргийг тодруулсан бичиг болой* (*Tabudugar Noyan Gegen-ten-ь jokiyagsan ngagra datshang-yin jayig diglem gьngjod-un jerge-yi todoragulugsan bicig bolai*) гэсэн гарчигтай. Дэвтэрийн хэлбэртэй энэхүү гар бичмэлийн цаасны хэмжээ 35.5422 см, гол хэсэг нь 10 хуудас 20 талтай, үргэлжлэлийн хэсэг нь 4 хуудас 8 талтай юм. Гол хэсэг, үргэлжлэлийн хэсгийн аль алины хуудсанд тус тусад нь дугаарыг тавьсан байна.

Агва дацан хэмээх нь төвд хэлний *sngags pa grwa tshang* гэсэн үгнээс гаралтай агаад дандарын ёсыг дагнан үзэх сургууль болно. 1940-өөд оны үед Өвөр монголын сүм хийдүүдэд очиж газар дээр нь судалгаа хийсэн Японы эрдэмтэн Нагао Гажин (Nagao Gajin) Улаанцавын Бадгар хийдэд байдаг Агва дацангий тухай дурдахдаа, Агва дацан нь жүдийн дацангаас хэмжээгээр бага, ном үзэх хугацаа нь ч богино байдаг гэж тэмдэглэсэн байдаг.⁵ Данзанравжаа залуулаа Бадгар хийдэд сурч байсан, өөрийн хийдэд анх барьсан хуралд Бадгарчойлин⁶ гэдэг нэр өгч байснаас үзэхэд Бадгар хийдээс үлэмж жишээ авсан нь тодорхой бөгөөд Хамарын хийдийн Агва дацан ч гэсэн Бадгар сүмийн дацантай үндсэндээ нэг л чиглэлтэй байсан гэх үндэстэй.

Дээрхи “жаяг дэглэм гүнжэд” гурван үг нь бүгд төвд үг хийгээд гүнжэд (төвдөөр *kun spyod*) хэмээх нь “бүх явдал” гэсэн утгатай нэр томъёо болно.

Хар бэхээр бичсэн гарчгийн хажууд сүүлд хөх өнгийн харандаагаар “Өмнөговь Цагаантолгой хэмээх хийдийн жаяг дэглэм” гэж монгол бичгээр нэмж бичсэн байна. Хэрвээ энэхүү цохвор зөв аваас тухайн Агва дацан нь Цагаантолгойн хийдэд байсан гэсэн үг. Гэвч Цагаантолгойн хийдэд Агва дацан байсан гэдэг мэдээ одоохондоо бид нарт олдоогүй байна. Чингэхлээр, Агва дацан хаана байсан бэ гэсэн асуудал зүй ёсоор гарч ирнэ. Миний бие тус Агва дацан нь Цагаантолгойн хийдийнх биш, харин Хамарын хийдийнх байх гэж үзэж байна. Гарчгийн хажууд буруу цохолт хийчихсэн учир шалтгааныг одоохол төдий л бэрх биш, Тус гар бичмэлийн эхний хуудсанд *Төр гэрэлтийн хорин гуравдугаар он хөхөгчин туулай жилд Ноён хутагтын тавдугаар гэгээнтний Галба уулын Бургасан Цагаан толгойн голын эх Улаан хаданд Ядам дацан, Пүрэв дацан байгуулсны тэмдэг* гэж монгол бичгээр бичсэн боловч, үнэндээ тийм тэмдэг нэг ч хуудас бичигдэлгүйгээр мөнөөх *Тавдугаар Ноён Гэгээнтний зохиосон Агва дацангийн жаяг дэглэм гүнжэдийн зэргийг тодруулсан бичиг болой* хэмээх зохиолтой шууд залгасан байна. Цохолт хийсэн хүн нь дээрхи нэгдүгээр гарчгийг үзээд андуурсан бололтой.

Төр гэрэлтийн хорин гуравдугаар он хөхөгчин туулай жил нь 1843 он болно. Данзанравжаагийн өөрийн бичсэн намтарт 1843 онд “Доржсэмбэ, Ядам, Пүрэв-нуудыг бүтээж тус тус цагийн хурал зургаан цагийн солх тэргүүтнийг тогтоон”⁷ гэж тэмдэглэсэн нь дацангууд байгуулсныг хэлж байна. Энд Агва дацангийн нэр ороогүйг анхаарах хэрэгтэй юм.

Данзанравжаагийн намтарт Агва дацан хоёр удаа дурдагджээ. Нэгдэх нь “Хонин жилээс эхлэн Агва тэргүүтэн хэдэн дацан хурал байгуулав”⁸ гэсэн хэсэг юм. Энд хонин жил хэмээх нь 1823 оныг хэлж буй. Иймээс Хамарын хийдийн Агва дацан 1823 оны үеэс үүсэлтэйг мэдэж болно.

5. Nagao Gajin, *Mouko Gakumonji*, Tokyo, 1992 (1947), p. 138.

6. Бадгар зуугийн цанид дацангийн нэр мөн гэж Л.Хүрэлбаатар багш тайлбарлажээ. Л.Хүрэлбаатар, *Аварга могойн зулайн чандмань*, Улаанбаатар, 2006, p. 340.

7. *Tabudugar Noyan Gegen-ten-ий cadig-un tobci quriyanggui orosibai*, 13 v. Л.Хүрэлбаатар, *Аварга могойн зулайн чандмань*, Улаанбаатар, 2006, p. 412. Монгол Улсын Үндэсний Номын Сангийн сан хөмрөгт хадгалагдаж байсан бичмэлийг анх эрдэмтэн Г.Лхагвасүрэн кирилл болгож, 1993 онд *Ноён хутагт Данзанравжаа* хэмээх номд хавсаргажээ. Дараа нь талийгаач Проф. Л.Хүрэлбаатар дээрхи номд латин галиг, кирилл эх, тайлбарын хамт монгол бичгийн хуулбар эхийг нийтэлжээ.

8. *Tabudugar Noyan Gegen-ten-ий cadig-un tobci quriyanggui orosibai*, 6 r. Л.Хүрэлбаатар, *Аварга могойн зулайн чандмань*, Улаанбаатар, 2006, p. 405.

Х.Фүтаки

Бас мөн намтарт гахай жил буюу 1827 онд “Агва дацанд олон шавь нар бодь сэтгэл үүсгэхүйн зан үйлсийг дэлгэрэнгүйгээ уншиж барив”⁹ гэж тэмдэглэжээ.

Тус Агва дацангийн жаягийн үргэлжлэлийн хэсэгт “Сан-аг Дэчин чойнхорлин” (төвд хэлээр *sngags sde chen chos 'khor ling*) гэж бичсэн тул үүнийг тус дацангийн албан ёсны нэр гэж үзэж болно.

Агва дацангийн жаягийг хэдийд зохиосон нь тодорхой биш авч 1823 оноос хойш байж таарна. Нөгөөтэйгүүр, тус жаягийн дотор “хуучин жаяг”¹⁰ гэсэн үг тохиолддог. Энэ нь “Агва дацан, Гандан дацан, Даншиг Чойнхорлингийн дэглэм гүнжэдийн зэргийг тодруулах” зорилгоор тогтоосон “жаяг дорж тимгай”¹¹ хэмээхийг хэлж байгаа шиг байна. Мөнөөх жаягт заагаагүй асуудал үүсвэл “жаяг дорж тимгайг” лавлахыг сануулж байгаагаас¹² харахад энэхүү “жаяг дорж тимгай” нь Хамарын хийдийн ерөнхий дүрмийн шинжтэй шашины журам байсан бололтой юм.

Жаягийн эхний хэсэгт хурлын тухай нарийн дүрмийг оруулжээ. “Энэ дацангийн үргэлжийн (байнгын) хурлаас гадна, дүйцэнгүүд нь сар бүрийн дүйцэнгүүдэд зэдтэй хурал дөрөв, зэдгүй нь дөрөв” “Гончгийн дүйцэнгүүд нь хаврын тэргүүн сарын 18-нд дунд дүрийн гончгийн дүйцэн, 4 манзны Маань дантай, Норжидмаа (?) 7, зэд 11, цавгүй, хаврын сүүл сарын 13-нд анхны дүрийн гончгийн дүйцэн 4 манзны Итгэл, Шавдаг дором 5 зэд цавгүй, зуны эхэн сарын 15-нд дөрөвдүгээр дүрийн гончгийн дүйцэн 3 манзны Ногоон Дарь эх, 1 манзны Самбалхүндэв, зэд 11, цавгүй, өвлийн сүүл сарын 27-нд өвгөн дүрийн гончгийн дүйцэнд Базарваань Жамсран 360 дангагтай (?), манз 4 хүний тоогоор авмуй, цавгүй зэд 11 буй. Гончгийн дүйцэнгийн өдөр Гомбо бус хурал үгүй. Сар бүрийн дүйцэн ба гончгийн дүйцэнлүгээ нэг жилд 11 өдрийн хурал буй”¹³ Энд гончгийн дүйцэн хэмээх нь Тавдугаар Ноён хутагтын өмнөх дөрвөн дүрд зориулсан хурлыг хэлж байна. Эдгээр тэмдэглэл нь тус дацангийн хурлын үйл ажиллагааг бодитойгоор үзүүлэх үндсэн материал болж байна.

Хар хүний суудаг орон зай болоод хуврагийн амьдардаг хэсгийг зааглах хил нь сүм хийдийг тойрох горлом зам болно. Энэхүү заагийг хамаагүй давуулахгүйн тулд нарийн журам тогтоожээ. “Горломын дотор нохой, хятад, бүсгүй хүн, галзуу тэргүүтнийг үл суулгаму. Горлом дотор хятад ба бүсгүйг үл хонуулму. Магад их өвчтэн ба, тавин нас хүрсэн их ноёд өглөгийн эздийн хатад тэргүүтэн эрх мягсалтай”¹⁴ буй бөгөөс хонуулах хүн гэвгүйд сүйж цөөн хонуулму. Тун аргагүй элэгдэх ба хөрч үхэх мэт сургаал болох цаг ба тун ялсан (?) болбаас гэсгүйд гомбоо сүйж¹⁵ хонуулму. Бас ч өвлийн дунд сарын арван дөрвөн, бичин жилийн бичин сарын бичин өдөр ба жил бүрийн гахай сарын арван, өвлийн дунд сарын хорин таван Же Зонховын мандсан өдөр 30 буюу цагаан сарын шинийн нэгэн, зуны эхний арван таван энэ долоон өдөрт тааралдаж ирэгсэд мягсалтныг гэвгүйд гомбоо олбаас болмуй. Үл олбаас болохгүй”¹⁶

9. *Tabudugar Noyan Gegen-ten-ü cadig-un tobci quriyanggui orosihai*, 8 т. Л.Хүрэлбаатар, *Аварга могойн зулайн чандмань*, Улаанбаатар, 2006, р. 407.

10. *Tabudugar Noyan Gegen-ten-ü jokiyagsan ngagpa datshang-yin jayig diglem güngjod-un jerge-yi todoragulugsan bicig bolai*, 3 v.

11. *Ibid.*, 1 v. Дорж тимгай (төвд хэлээр *rdo rje 'i them skas*) нь “очрын шат” гэсэн утгатай.

11.. *Ibid.*, 10 v.

12. *Ibid.*, 1 v. - 2г.

14. Төвд хэлний *dmigs gsal* (онцгой тохиолдол) гэсэн үгнээс гаралтай гэж үзжээ.

15. *gombo-a süikü* (-*süikü*) буюу гомбоо сүйх нь төвд хэлний *dgongs pa zhu* (чөлөө айлтгал) гэсэн үгнээс гаралтай нэр томъёо болно гэж Л.Хүрэлбаатар багш тайлбарлаж өгсөн билээ. Тус жаягт зөвшөөрөл гуйх гэсэн утгаар энэ үг олон хэрэглэгдсэн байдаг.

16. *Tabudugar Noyan Gegen-ten-ü jokiyagsan ngagpa datshang-yin jayig diglem güngjod-un jerge-yi todoragulugsan bicig bolai*, 6 т.

Х.Фүтаки

Дээр иш татсан заалтаас дацанд бүсгүйчүүд хонуулахыг хориглосон зүйл. Зонховын жанч халсан өдрийг чухалчилсан зүйлд анхаарлаа хандуулах нь зүйтэй. Эдгээр журам нь бусад шарын шашны сүм хийдэд баримтлаж байсан дэгтэй зөрөхгүй байх.

Тус жаягийг зохиоход ашигласан жаяг дэглэмийн тухай Данзанравжаа өөрөө тодорхой дурдсан байдаг. Үүнд “бурханы таалсан винай цааз ба энэтхэг төвдийн олон мэргэдийн жаяг дэлгэрэнгүй дунд хураангуй зэрэг жаяг хийгээд түүний тааллыг тодруулсан Тавдугаар Далай Ламын жаяг, Жалба Галсанжамц, Банчин Балдан-Ишийн жаяг, “*sembri gesum caglin*”, Жанжаа Ролбийдорж, Туган Дарма тэргүүтний зохиосон олон зүйл жаяг, Бадгарчойлингийн дэглэм тэргүүтнийг гол барьж”¹⁷ гэж тэмдэглэжээ. Үүний дотор “*sembri gesum caglin*” хэмээх нь төвд хэлний *se 'bras dge gsum phyag len* мөн бөгөөд Лхасын Сэра Бэрээвэн I андан гурван хийдийн дүрмийг зааж байна. Жалба Галсанжамц, Банчин Балдан-Иш нь тус тус Долоодугаар Далай Лам Галсанжамц, Зургаадугаар Банчин Лам Лувсанбалдан-Ишийг хэлжээ. Хоёрдугаар Жанжаа хутагт Ролбийдоржийн тухай тайлбарлах шаардлагагүй байх. Туган Дарма бол Гуравдугаар Туган хутагт Лувсанчойжням мөн юм.¹⁸ Дээр өгүүлсэнчлэн Бадгарчойлин нь одоо ч Өвөр Монголын Бугат хотод байгаа, чойрын ёсоор алдаршсан Бадгар сүмийн цанид дацан мөн бөгөөд Данзанравжаа өөрөө залуудаа нэг хэсэг энэ дацанд сурч байсан байна.

Дээр иш татсан тус жаягийн эх үүсвэр нь бүгд шарын шашин буюу Гэлүгвагийн хутагтын тогтоосон дүрэм, эсвэл Гэлүгвагийн нэртэй хийдэд баримталдаг дэглэм юм. Энэ нь Ноён хутагт Гэлүгвагийн уламжлалыг дагадаг байсныг маш тодорхой харуулж буй.¹⁹

Тус жаягийг тогтооход монголчуудын амьдрал нөхцөлд тааруулж дүрмийг зориуд хөнгөлүүлснийг Данзанравжаа өөрөө тайлбарласан хэсэг нь бидний анхаарлыг татаж байна. Үүнд “Саримсаг идвээс хурлаас долонь хоног хорих зэргийг үүнд таван хоног болгосон” “Архийг гурвантаа ууваас хөөхөөр таалсныг олонтаа шийтгэхийг тогтоосон” зэрэг жишээг дурдсан аж.

Жаягийн дотор саримсаг идсэн хүнийг шийтгэх тухай доорхи мэт заасан байна. “Лууван идвээ нэг өдөр, сонгино идвээ гурван хоног, саримсагт таван хоног хурлаас хорьму” Мөн архи уусан хуврагийн тухайд “нэг ууваас гурван хоног хурлаас хориод гурвантаа ууваас манз чануулан хуралд нүцгэлж дуганы үүдэнд сөгтгөөд хоосон лонх бариулж горлом эргүүлгүй” гэж заажээ. Энэхүү заалт нь дацанд архи уухыг хориглодог байсан боловч, дэндүү хагуу шийтгэл өгөөгүйг харуулж байгаагаараа сонирхолтой.

Ноён хутагт цаашид “Орон цагийн эрхээр энэтхэг төвд монгол гурав цөм нэгэн адил байх бэрх тул, төвд зориг зоригтой тул лаглэн (төвдөөр *lag len*, зан ёс) хүнд, монгол мартамтгай тул цогдам (төвдөөр *tshogs gtam*, яриа) олон зэргийн ялгал ч олон буй” гэж дурдаж улс орны нөхцлийг харгалзаж дүрмийг нь ялгаварлан тогтоох нь чухал гэжээ. Энэ бол монголчуудын нөхцөл байдалд тохирсон бурханы шашныг бий болгох саналыг дэвшүүлснээрээ үлэмж ач холбогдолтой юм.

Зарим судлаачид Данзанравжаагийн хувийн амьдралын зарим хэсгийг үндэс болгож түүний байгуулсан Хамарын хийдийг Гаажүдва ёсны гол хийд гэж ойлгосон боловч²⁰, тус жаягийн агуулга, мөн эх үүсврээс нь үзэхэд тэрхүү ойлголтыг хүлээн авах боломжгүй нь илэрхий

17. *Ibid.*, 10 v.

18. Туган Лувсанчойжням Өвөр Монголын Зүүн Сөнөд, Үүшин, Отог зэрэг хошууны сүмд зориулж жаяг зохиожээ. E. Gene Smith, *Among Tibetan Texts: History and Literature of the Himalayan Plateau*, Boston, 2001, p. 156.

19

20. С. Цэдэндамба, *Монголын сүм хийдийн түүхэн товчоон*, Улаанбаатар, 2009, p. 376.

Х.Фүтаки

болж байна. Данзанравжаа Гэлүгва ёсыг гол болгосон мөртлөө монголчуудын ахуй нөхцөлд нийцсэн, монгол маягийн буддын шашныг бий болгохыг оролдож байсан гэж үзэх нь зөв мэт санагдана. Бурханы шашин монголчуудын нийгэмд бүрэн нэвтэрснээс хойш 200 гаруй жил өнгөрч монголжсон бурханы шашин бүрэлдэж эхэлсэн гэж ойлгоход буруудахгүй байх.

Дүгнэж хэлэхэд нэгдүгээрт, тус жаяг нь Данзанравжаагийн шашны талаархи үзэл санааг судлахад үндсэн баримт болох нь дамжиггүй юм. Хоёрдугаарт, тус зохиол нь XIX зууны үед сүм хийд, түүнд сууж байсан лам хувраг болоод хар хүн буюу энгийн хүмүүсийн харилцаа холбоог харуулах үнэ цэнэтэй материал болох тул тухайн үеийн монголын нийгэм, соёлын түүхийг гүнзгийрүүлэн судлахад чухал сурвалж болно гэж найдаж байна.

Энэхүү өгүүллийг Данзанравжаагийн зохиосон тус жаягийн төгсгөлийн шүлгээр өндөрлөө.

Түүнчлэн ирэгсэд бүгдийн үзүүлсэн хөлгөний утга

Төгс хувьт олон амьтан бүгдийн орох гагц зам

Төр шажны утга барилдсан жаяг энэ бээр

Төрэлгүй амьтанд үүрд туслах болтугай

Аа²¹

21. *Tahudugar Noyan Gegen-ten-ü joki-yagsan ngagpa datshung-yin jayig diglem güngjod-un jerge-yi todoragulugsan bicig bilai*, 10 v.

Х.Фүтаки
НОМ ЗҮЙ

Tabudugar Noyan Gegen-ten-ь jokiyagsan ngagpa datshang-yin jayig diglem gьngjod-un jerge-yi todoragulugsan bicig bolai. бичмэл, хувийн цуглуулга.

Tabudugar Noyan Gegen-ten-ь cadig-un tobci quriyanggui orosibai, бичмэл, Монгол Улсын Үндэсний Номын Сан.

Лхагвасүрэн Г., *Ноён хутагт Данзанравжаа.* Улаанбаатар, 1993.

Хүрэлбаатар Л., *Аварга могойн зулайн чандмань.* Улаанбаатар, 2006.

Цэдэндамба С., *Моноглын сүм хийдийн түүхэн товчоон.* Улаанбаатар, 2009.

Цэрэнсодном Д., *Монголын бурханы шашны уран зохиол, тэргүүн дэвтэр.* Улаанбаатар, 1997.

E. Gene Smith, *Among Tibetan Texts: History and Literature of the Himalayan Plateau.* Boston, 2001.

Nagao Gajin, *Mouko Gakumonji,* Tokyo, 1992 (1947).